Урт хугацаат түрээсийн өглөг	1,922,734	1,710,773
Урт хугацаат зээл	36,210,000	51,933,267
Хойшлогдсон татварын өглөг	13,939,844	13,939,844

52,072,578 67,583,884

Нийт өр төлбөрийн дүн

304,820,376 405,358,442

Эзэмшигчдийн өмч

Хувьцаат капитал	780,113	780,113
Дахин үнэлгээний нэмэгдэл	43,777,386	43,777,386
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(12,119,789)	(27,343,813)
Хуримтлагдсан алдагдал	(30,980,585)	(40,980,569)

1,457,125 (23,766,883)

Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн

306,277,501 381,591,559

1.2.	Орлогын тайлан		
	"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН		<i>(мян.төг)</i>
		2024.12.31	2025.09.30
	Борлуулалтын орлого	247,026,317	164,037,609
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(138,552,341)	(87,435,656)
	Нийт ашиг	108,473,976	76,601,953
	Бусад орлого	3,649,691	4,106,974
	Борлуулалт ба маркетингийн зардал	(53,217,129)	(39,463,511)
	Ерөнхий ба удирдлагын зардал	(24,908,151)	(19,022,054)
	Бусад зардал	(6,919,419)	(2,591,049)
	Санхүүгийн орлого	4,465,583	14,160
	Санхүүгийн зардал	(33,118,100)	(26,600,246)
	Татварын өмнөх алдагдал	(1,573,549)	(6,953,772)
	Орлогын татварын өгөөж (зардал)	(2,083,660)	(3,046,212)
	Тайлант жилийн цэвэр алдагдал	(3,657,209)	(9,999,984)
	Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжтой бусад дэлгэрэнгүй орлого:		
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөлөөлөл	32,341,972	-
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний татварын нөлөөлөл	(8,085,493)	-
	Гадаад дахь охин компаниудын цэвэр хөрөнгийн гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү	(1,457,515)	(15,224,024)
	Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй (алдагдал) орлого	22,798,964	(15,224,024)
	Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	19,141,755	(25,224,008)

1.3.	<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>					
	"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН					<i>(мян.төг)</i>
	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нөөц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт	
	2024 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	780,113	20,514,269	(10,662,273)	(28,316,738)	(17,684,629)
	Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(3,657,209)	(3,657,209)
	Бусад дэлгэрэнгүй орлого	-	24,256,479	(1,457,516)	-	22,798,963
	Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	-	24,256,479	(1,457,516)	(3,657,209)	19,141,754
	Хуримтлагдсан ашиг уруу шилжүүлсэн	-	(993,362)	-	993,362	-
	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	780,113	43,777,386	(12,119,789)	(30,980,585)	1,457,125
	Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(9,999,984)	(9,999,984)
	Бусад дэлгэрэнгүй алдагдал	-	-	(15,224,024)	-	(15,224,024)
	Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	-	-	(15,224,024)	(9,999,984)	(25,224,008)
	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
	2025 оны 09 сарын 30-ны үлдэгдэл	780,113	43,777,386	(27,343,812)	(40,980,569)	(23,766,883)
1.4.	<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>					
	"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН					<i>(мян.төг)</i>
				2024.12.31	2025.09.30	
	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ			29,728,027	(30,395,655)	
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ			(21,049,750)	(3,803,360)	
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ			(12,361,396)	58,020,263	
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ			(3,683,119)	23,821,248	
	Гадаад үйл ажиллагааг хөрвүүлсэн гадаад валютын ханшийн зөрүү			(1,457,516)	-	
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл			(24,430)	246,591	
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			9,491,111	4,326,046	
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			4,326,046	28,393,885	

2. Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны дүгнэлт



“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ
ЭРСДЭЛ АУДИТЫН ХОРООНЫ
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Г 2025 оны 3-р улирлын санхүүгийн тайланг дүгнэх тухай Г

Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”, Говь ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх “Эрсдэл, аудитын хорооны үйл ажиллагааны журам”-ын 3.1.1.1-р заалтыг тус тус үндэслэн Эрсдэл, аудитын хорооны хурлаас **ТОГТООХ нь:**

2.

1. Говь ХК-ийн 2025 оны 3-р улирлын санхүүгийн тайлан нь холбогдох хууль, дүрэм журам, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн болохыг хүлээн зөвшөөрч байгаа тул олон нийтэд мэдээлэхийг зөвшөөрсүгэй.
2. 3-р улирлын тайланг холбогдох журмын дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж-д хүргүүлэн олон нийтэд тайлагнан ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д үүрэг болгосугай.

ЭРСДЭЛ, АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА

ГИШҮҮД



А.ЖАРГАЛМАА

Д.ГЭРЭЛМАА

Б.ЦЭЭНЯМ

3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт																		
3.1.	<table border="1" data-bbox="647 275 1455 546"> <thead> <tr> <th data-bbox="647 275 1046 320">Үзүүлэлт</th> <th data-bbox="1046 275 1257 320">2024.09.30</th> <th data-bbox="1257 275 1455 320">2025.09.30</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="647 320 1046 360">Бохир ашгийн маржин</td> <td data-bbox="1046 320 1257 360">43%</td> <td data-bbox="1257 320 1455 360">47%</td> </tr> <tr> <td data-bbox="647 360 1046 400">Цэвэр ашгийн маржин</td> <td data-bbox="1046 360 1257 400">-3%</td> <td data-bbox="1257 360 1455 400">-6%</td> </tr> <tr> <td data-bbox="647 400 1046 441">Эргэлтийн харьцаа</td> <td data-bbox="1046 400 1257 441">0.7</td> <td data-bbox="1257 400 1455 441">0.7</td> </tr> <tr> <td data-bbox="647 441 1046 506">Бараа материалын эргэц</td> <td data-bbox="1046 441 1257 506">417</td> <td data-bbox="1257 441 1455 506">430</td> </tr> <tr> <td data-bbox="647 506 1046 546">Хувьцааны нэгж үнэ /₮/</td> <td data-bbox="1046 506 1257 546">255</td> <td data-bbox="1257 506 1455 546">236</td> </tr> </tbody> </table>	Үзүүлэлт	2024.09.30	2025.09.30	Бохир ашгийн маржин	43%	47%	Цэвэр ашгийн маржин	-3%	-6%	Эргэлтийн харьцаа	0.7	0.7	Бараа материалын эргэц	417	430	Хувьцааны нэгж үнэ /₮/	255	236
Үзүүлэлт	2024.09.30	2025.09.30																	
Бохир ашгийн маржин	43%	47%																	
Цэвэр ашгийн маржин	-3%	-6%																	
Эргэлтийн харьцаа	0.7	0.7																	
Бараа материалын эргэц	417	430																	
Хувьцааны нэгж үнэ /₮/	255	236																	
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт																		
3.3.	<p data-bbox="244 1137 619 1503">Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</p> <ul data-bbox="638 593 1449 2054" style="list-style-type: none"> • 2025 оны 3-р улирлын байдлаар борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 2%-аар буурсан. Нийт борлуулалтын 85%-ийг дотоод, 15%-ийг гадаад зах зээл эзэлж байна. • Бүтээгдэхүүний загварын тоог бууруулж, өмнө нь худалдаанд гарч байсан, эрэлт ихтэй загваруудын масс үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэн. Ингэснээр хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн өнгө, размерын сонголт нэмэгдсэн. • Дотоодын зах зээлд бүтээгдэхүүний үнийн бодлогыг шинэчлэн, ижил төстэй загвартай бүтээгдэхүүн хоорондын үнийн ялгааг бууруулахад анхаарч ажилласнаар хэрэглэгчид сонголт хийхэд хялбар болсон. Мөн социал маркетингийг 2-р сараас илүү идэвхтэй болгосон нь дотоодын худалдан авалтыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн. 3-р сарын 1-нд Чингис Хаан Олон Улсын Нисэх Буудалд салбар дэлгүүрээ нээсэн. • Гадаад зах зээлд борлуулалтын сувгаа өргөжүүлж 1-р сараас АНУ-ын Macy's онлайн худалдааны платформор бүтээгдэхүүнээ борлуулж эхэлсэн. Мөн 9-р сарын 30-ны өдрөөс эхлэн дэлхийн хамгийн том онлайн худалдааны платформ болох "Amazon"-д албан ёсоор худалдаалагдаж эхлэв. • Дизайн хөгжүүлэлтийн хувьд CashmereTECH технологийн куртка, гутал болон бусад outsourcing бүтээгдэхүүний загвар технологийн сайжруулалт дээр анхаарч ажилласан. • Үйлдвэрлэлийн бүтээмжээ сайжруулах, өртгийг бууруулах хүрээнд 3D бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 2 дахин нэмэгдүүлснээр илүү бага хөдөлмөрөөр чанартай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг болсон. Мөн технологийн шинэчлэл хийж MES /Manufacturing Execution System/ болон дамжлагын системийг нэвтрүүлснээр үйлдвэрлэлийн удирдлага сайжирсан. • Говь ХК нь тогтвортой хөгжлийн зарчмуудыг 																		

		<p>хэрэгжүүлж, хариуцлагатай үйлдвэрлэл эрхлэх зорилгоор “Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо”-нд гишүүнээр элссэн. Мөн “Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого”-оо батлан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн Монгол ноолууран бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэдээ хүргэхийн тулд Монгол Улсын төдийгүй олон улсын стандартын шаардлагыг хангаж, удирдлагын тогтолцоогоо тасралтгүй сайжруулж байна. • Говь ХК-ийн 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн хэлбэрийг өөрчилж, хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) болохоор шийдвэрлэсэн. Энэхүү шийдвэртэй холбоотой Компанийн тухай хууль болон бусад эрх бүхий зохицуулагч байгууллагаас баталсан дүрэм журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн “хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх”-ийг хэрэгжүүлж, хувьцаа эзэмшигчдээс өөрийн эзэмшлийн хувьцааг худалдаж авахыг компаниас шаардах хүсэлт, эсхүл компанид хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хуулийн дагуу ажлын 30 хоногийн хугацаанд буюу 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийг дуустал хүлээн авч байна.
3.4.	<p>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</p>	<p>Санхүүгийн байдлын гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.</p>
4.	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>
		<p>ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ</p> <p>Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгээгүй.</p> <p>СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ</p> <p>Говь ХК-ийн “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ын дагуу жил бүрийн эхэнд Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах хэлцэл хийхийг зөвшөөрсөн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн жагсаалт болон хэлцлийн төсвийг ТУЗ-ийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар баталдаг.</p> <p>Дээрх журмын дагуу батлагдсан жагсаалтад ороогүй этгээдтэй хийх болон батлагдсан төсвөөс хэтэрсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийх бүрд</p>

тухайлсан тогтоолоор ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн зөвшөөрөл олгодог.

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо нь Компанийн хэмжээнд хийгдэж буй сонирхлын зөрчилтэй хэлцэл нь батлагдсан төсвийн хүрээнд, зах зээлийн үнэ нөхцөлөөр, хуулийн дагуу хийгдэж байгаа эсэх дээр улирал бүрийн хорооны хурлаараа дамжуулан тогтмол хяналт тавьж ажилладаг.

2025 оны хувьд ТУЗ-ийн 2025 оны 03-р сарын 20-ны [№07 тоот](#) тогтоолоор тус зөвшөөрлийг олгосон.

2025 оны эхний хагас жилийн сонирхлын зөрчилтэй хэлцлийн гүйцэтгэлтэй 2025 оны 07-р сарын 07-ны Эрсдэл, аудитын хорооны ээлжит хурал дээр танилцан хяналт тавьсан.

2025 ОНЫ 3-Р УЛИРЛЫН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Огноо	Гэрээ хэлцлийн утга	Үнийн дүн	Гэрээний нөгөө тал	Гэрээний нөхцөл, болзол	Эхлэх огноо	Дуусах огноо	Хэлцэл баталсан
2025.04.02	Хаан банкны зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	Зээлийн эрхийн хэмжээг 14 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх	Хаан Банк ХК	Таван Богд Холдингс ХХК болон түүний охин компаниудтай хамтарсан зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	2024.12.31	2027.12.31	ТУЗ-ийн тогтоол №13
2025.04.09	Хэвлэх үйлчилгээ авах	11.8 сая төгрөг	Улаанбаатар Принт ХХК	Хэвлэх үйлчилгээ авах	2025.03	2025.03	ТУЗ-ийн тогтоол №15
2025.05.14	Эргэлтийн хөрөнгийн ногоон зээлийн гэрээ байгуулах тухай	6 тэрбум төгрөг	Хаан Банк ХК	Ноос, ноолуур, арьс ширний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгийн ногоон зээл авах	2025.05.14	2027.05.14	ТУЗ-ийн тогтоол №21
2025.06.19	Андеррайтерийн үйлчилгээний гэрээ байгуулахыг зөвшөөрөх тухай	400 сая төгрөг	Таван Богд Капитал ҮЦК ХХК	Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх	2025.06.20	-	ТУЗ-ийн тогтоол №27
2025.09.09	Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх болон түүнтэй холбоотой журам батлах, хувьцаа худалдаж авах тухай зөвшөөрөл олгох, эргүүлэн худалдан авах хувьцааны үнийг тогтоох тухай	-	Таван Богд Холдингс ХХК	Шаардах эрх хэрэгжүүлсэн хувьцааг тогтоолд заасан үнэ, журмын дагуу худалдан авах	2025.09.11	2025.10.23	ТУЗ-ийн тогтоол №39
2025.09.09	Брокерын үйлчилгээ үзүүлэх үнэт цаасны компанийг сонгох тухай	-	Таван Богд Капитал ҮЦК ХХК	Брокерын үйлчилгээ үзүүлэх	2025.09.11	2025.10.23	ТУЗ-ийн тогтоол №40

ХОЛБООТОЙ ТАЛУУДАЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭ

(мян.төг)

Холбоотой талуудтай хийсэн гүйлгээ	2024.09.30	2025.09.30
Холбоотой талд өгсөн санхүүжилт	420,714,048	268,217,177
Холбоотой талаас авсан санхүүжилт	450,587,288	267,849,331
Холбоотой талтай хийсэн борлуулалт	126,881	694,386
Холбоотой талаас авсан худалдан авалт	1,404,916	1,336,836
Хүүгийн орлого	-	631,425
Хүүгийн зардал	5,910,245	4,342,847
Түрээсийн орлого	204,396	419,024
Түрээсийн зардал	1,033,790	1,116,420

Жич: Холбоотой талууд гэдэгт Таван Богд Группийн охин компаниуд орсон болно.

Эдгээр холбоотой талуудтай компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах зөвшөөрлийг ТУЗ-ийн 2025 оны 03-р сарын 20-ны [№07 тоот](#) тогтоолоор олгосон.

5.


Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл

Олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.

6.

Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



Таван Богд Холдингс ХХК

НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО

780,112,500

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО

25,298

/2025.09.30-ны байдлаар/

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

Хувьцаа эзэмшигчийн нэр	2024.12.31		2025.09.30	
	Хувьцааны тоо ширхэг	Хувь	Хувьцааны тоо ширхэг	Хувь
Таван Богд Холдингс ХХК	681,267,736	87.33%	682,096,188	87.44%

Тайлант хугацаанд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт ороогүй бөгөөд хувь эзэмшил нь 0.11% нэмэгдсэн.

2025 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04-р сарын 25-ны өдрийн 14:00 цагт ХААН театр (Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж-25, Хаан банкны Сөүл оффисын 1 давхар)-т амжилттай зохион байгуулагдав.

Хурлын ирц

Хуралд урьдчилан санал өгөх арга хэлбэрээр нийт 13,341,856 ширхэг хувьцааны 1.71 хувийн саналын эрхтэй 563 хувьцаа эзэмшигч, хурлын өдөр биечлэн оролцох арга хэлбэрээр 681,455,412 ширхэг хувьцааны 87.35 хувийн саналын эрхтэй 99 хувьцаа эзэмшигч буюу нийт 694,797,268 ширхэг хувьцааны саналын эрхтэй 662 хувьцаа эзэмшигч оролцсоноор хурлын ирц 89.06% болж бүрдэн хурал хүчин төгөлдөр явагдав.

Хурлаар танилцуулсан асуудал

1. Говь ХК-ийн 2024 оны санхүү үр дүн болон үйл ажиллагааны тайлан;
2. 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараахгүй тухай ТУЗ-ийн тогтоол;
3. ТУЗ-өөс компанийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар гаргасан дүгнэлт;
4. Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл;
5. ТУЗ-ийн 2024 оны ажлын тайлан, 2025 оны цалингийн төсөв;
6. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга.

Хурлаас гарсан шийдвэр

Хувьцаа эзэмшигчид дээрх асуудлуудтай холбогдох тайлан илтгэлүүдийг сонсож, асуулт хариулт болон санал хүсэлтээ хэлэлцсэний эцэст саналын хуудсаар саналаа өгсөн бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараах [шийдвэрийг](#) гаргав.

1. ТУЗ-өөс компанийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг 99.99%-ийн саналаар батлав.
2. Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг 99.99%-ийн саналаар батлав.
3. ТУЗ-ийн 2025 оны цалингийн төсвийг 99.99%-ийн саналаар батлав.
4. ТУЗ-ийн гишүүдийг 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаатай сонгон томилов.

Хурлын дараах тайлан

Хурлын үеэр хувьцаа эзэмшигчдээс асуулт болон санал зөвлөмжийг хүлээн авч хурлын дараа эргэн холбогдож хариу өгч ажилласан.

2025 оны 04-р сарын 30-ны өдөр ХЭХ-ын материал (Хурлын хэлэлцэх асуудалтай холбоотой 30 хуудас бүхий хэвлэмэл материал 1 ширхэг, Хурлын тайлан болох 110 хуудас хэвлэмэл материал 1 багц, 2 цахим хэлбэрийн материал)-ыг СЗХ, МХБ-д тус тус хүргүүлэн, хуулийн хугацаанд тайлагнан ажилласан.

2025 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2025 оны 09-р сарын 08-ны өдрийн 14:00 цагт ГОВЬ ХК (Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК-ийн өөрийн байр, 1-р давхар, Сургалтын танхим)-д 89.36% ирцтэйгээр амжилттай зохион байгуулагдав.

Хурлын ирц

Хуралд урьдчилан санал өгөх арга хэлбэрээр нийт 14,866,699 ширхэг

хувьцааны 1.91 хувийн саналын эрхтэй 475 хувьцаа эзэмшигч, хурлын өдөр биечлэн оролцох арга хэлбэрээр 682,231,660 ширхэг хувьцааны 87.45 хувийн саналын эрхтэй 31 хувьцаа эзэмшигч буюу нийт 697,098,359 ширхэг хувьцааны саналын эрхтэй 506 хувьцаа эзэмшигч оролцсоноор хурлын ирц 89.36% болж бүрдэн хурал хүчин төгөлдөр явагдав.

Хурлаар хэлэлцсэн асуудал

1. Компанийн хэлбэрийг өөрчлөх;
2. Компанийн дүрмийг шинээр батлах.

Хурлаас гарсан шийдвэр

Хувьцаа эзэмшигчид дээрх асуудлуудтай холбогдох илтгэлүүдийг сонсож, асуулт хариулт болон санал хүсэлтээ хэлэлцсэний эцэст саналын хуудсаар саналаа өгсөн бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас дараах [шийдвэрийг](#) гаргав.

1. Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай асуудлыг 99.99%-ийн саналаар батлав.
2. Компанийн хэлбэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Говь ХХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг 99.99%-ийн саналаар батлав.

Хурлын дараах тайлан

Хурлын үеэр хувьцаа эзэмшигчдээс асуулт болон санал зөвлөмжийг хүлээн авч хурлын дараа эргэн холбогдож хариу өгч ажилласан.

2025 оны 09-р сарын 09-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тайлан, материал (Хурлын тайлан болох 82 хуудас хэвлэмэл материал 1 багц, 2 цахим хэлбэрийн материал)-ыг СЗХ, МХБ-д тус тус хүргүүлэн, хуулийн хугацаанд тайлагнан ажилласан.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЭЛСЭН ТУХАЙ

Говь ХК-ийн 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн хэлбэрийг өөрчилж, хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) болохоор шийдвэрлэсэн.

Тус шийдвэртэй холбогдуулан Компанийн тухай хуулийн 53,54,55 дугаар зүйл, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 23.4.3, 23.4.5, 23.5, 23.6, 23.9-д тус тус заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн “ХУВЬЦААГАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХЫГ КОМПАНИАС ШААРДАХ ЭРХ” (шаардах эрх)-ийг хуульд заасан журмын дагуу зохион байгуулахыг ТУЗ-д даалгасан.

ТУЗ-ийн 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн [№39 тоот](#) тогтоолоор шаардах эрхийг хэрэгжүүлэх шийдвэрийг гарган, түүнтэй холбоотой журмыг баталж, эргүүлэн худалдаж авах хувьцааны үнийг 259 төгрөгөөр тогтоосон. Мөн тус тогтоолд заасан үнэ, журмын дагуу шаардах эрх хэрэгжүүлэх хүсэлтээ ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авахыг компанийн хяналтын багцын хувьцааг эзэмшигч “Таван Богд Холдингс” ХХК-д зөвшөөрсөн. Хувьцаа эзэмшигчдийн шаардах эрхийг хэрэгжүүлэх шийдвэр нь Говь ХК-ийн зүгээс санаачилсан үйл ажиллагаа биш бөгөөд дээр дурдсан хууль болон журмын дагуу бусад хувьцаа эзэмшигчдэд хуулиар олгогдсон эрхийг хангаж буй үйл ажиллагаа юм.

Хувьцаа эзэмшигчдээс өөрийн эзэмшлийн хувьцааг худалдаж авахыг компаниас шаардах хүсэлт, эсхүл компанид хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хуулийн дагуу ажлын 30 хоногийн хугацаанд буюу 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийг дуустал

хүлээн авч байна.

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ӨӨРЧЛӨЛТ

- ТУЗ-ийн 2025 оны 01-р сарын 31-ний өдрийн [№02 тоот](#) тогтоолоор ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмааг 2025 оны 01-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болгон өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас чөлөөлж, 2025 оны 02-р сарын 01-ний өдрөөс эхлэн Ц.Баатарсайханыг томилов.
- ТУЗ-ийн 2025 оны 09-р сарын 10-ны өдрийн [№42 тоот](#) тогтоолоор ТУЗ-ийн дарга Ц.Баатарсайханыг 2025 оны 09-р сарын 09-ний өдрөөр дуусгавар болгон өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас чөлөөлж, 2025 оны 09-р сарын 10-ний өдрөөс эхлэн Д.Хуланг томилов.
- ТУЗ-ийн 2025 оны 09-р сарын 25-ны өдрийн [№45 тоот](#) тогтоолоор ТУЗ-ийн дарга Д.Хуланг 2025 оны 09-р сарын 24-ний өдрөөр дуусгавар болгон өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас чөлөөлж, 2025 оны 09-р сарын 25-ны өдрөөс эхлэн Ц.Баатарсайханыг томилов.

7. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

ТУЗ-ИЙН ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Хурал	Ээлжит хурал	Ээлжит бус хурал	Цахим санал хураалт	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр	Санал зөвлөмж	Үүрэг даалгавар	Баталсан тогтоол
ТУЗ-ийн хурал	3	2	19	56	59	6	4	46
Эрсдэл, аудитын хорооны хурал	3	-	2	23	10	12	8	3
Нэр дэвшүүлэх хорооны хурал	1	2	3	14	13	4	11	7
Цалин урамшууллын хорооны хурал	1	-	-	6	7	2	1	1
Нийт	8	4	24	99	89	24	24	57

Говь ХК-ийн ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2025 оны 3-р улирлын байдлаар нийт 8 ээлжит хурал, 4 ээлжит бус хурал, 24 цахим санал хураалт зохион байгуулж гишүүд идэвх санаачилгатай ажиллав.

ТУЗ-ИЙН ТОГТООЛ, ШИЙДВЭР

Тайлант хугацаанд ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нийт 99 асуудлыг хэлэлцэн, 89 шийдвэр гаргаж, 57 тогтоолыг баталсан. Үүнд:

- ТУЗ-өөс 46 тогтоол (үйл ажиллагаа өргөжүүлэхтэй холбоотой 1, дотоод үйл ажиллагаатай холбоотой 23, санхүүжилттэй холбоотой 13, хүний нөөцтэй холбоотой 9)
- Эрсдэл, аудитын хорооноос 3 тогтоол,
- Нэр дэвшүүлэх хорооноос 7 тогтоол,
- Цалин, урамшууллын хорооноос 1 тогтоол.

Мөн чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 24 санал зөвлөмж, 24 үүрэг даалгавруудыг өгч, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллав. ТУЗ-ийн шийдвэр болон үүрэг даалгаврын биелэлт 100% хэрэгжилттэй байв.

НОГДОЛ АШИГ

Говь ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 02-р сарын 07-ны өдрийн [№02 тоот](#) тогтоолын дагуу компанийн 2024 оны санхүүгийн үр дүн нь компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийг хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ

Эхний хагас жилийн байдлаар дараах тайлан мэдээллийг хуулийн хугацаанд СЗХ болон МХБ рүү илгээн, олон нийтэд тайлагнан ажилласан.

- 2024 оны Жилийн үйл ажиллагааны тайлан (Монгол, Англи хэлээр);
- 2024 оны Аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт (Монгол, Англи хэлээр);
- 2024 оны Байгаль орчин, нийгэм, засаглалын үйл ажиллагааны тайлан;
- 2025 оны 1-р улирал болон хагс жилийн санхүү, үйл ажиллагааны тайлан (Монгол, Англи хэлээр);
- 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал, 2025.09.08-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зохион байгуулсан тайлан материал;
- 2024 оны жилийн эцэс болон 2025 оны хагас жилийн байдлаарх Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлан (Монгол, Англи хэлээр);
- Тухай бүр хүргэх мэдээллүүд.

ШИНЭЭР БАТЛАГДСАН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

2025 оны 3-р улирлын байдлаар ТУЗ-өөс дараах бодлого, журмыг баталсан. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 1-р сарын Эрсдэл, аудитын хорооны хурлаар хэлэлцэн, ТУЗ-ийн 03-р сарын 20-ны [№08 тоот](#) тогтоолоор шинэчлэн баталсан.
- Дотоод аудитын дүрмийг Эрсдэл, аудитын хорооны хагас жилийн хурлаар хэлэлцэн баталсан.

Засаглалтай холбоотой дэлгэрэнгүй тайлан мэдээлэлтэй Хавсралт дахь үйл ажиллагааны тайлангаас танилцана уу.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Амарсайхан

Албан тушаал: "Говь" ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: М.Сэлэнгэ

Албан тушаал: "Говь" ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:

Огноо: 2025 оны 10-р сарын 20-ны өдөр